



ТӨВ АЙМГИЙН  
БАЯНДЭЛГЭР СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 05 сарын 06 өдөр

Дугаар 20

Баяндэлгэр уул

Г ЖУРАМ БОЛОВСРУУЛЖ ХЭЛЭЛЦҮҮЛЭХ ТУХАЙ Г

Монгол улсын “Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.13 дахь заалтыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг ээлжит бус наймдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Сум орон нутгийн чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд зайлшгүй шаардлагатай байгаа дараах журмуудыг хууль тогтоомжийн дагуу боловсруулж 2022 онд багтаан иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар хэлэлцүүлэхийг хурлын зөвлөл (Ц.Энхтүвшин) болон засаг дарга З.Дэлгэрцэцэг нарт үүрэг болгосугай. Үүнд:

- 1.1. Суурин мал маллагааны бүс тогтоож журам батлах тухай.
- 1.2. Орон нутгийн өмчид бүртгэлтэй орон сууцны түрээсийн журам
- 1.3. “Улсын төсвөөр гаргасан худаг уст цэгийн эзэмшил, ашиглалтын тухай” журам боловсруулж батлуулах тухай.
- 1.4. Сумын төвд нохой муур тэжээх, золбин муур нохой устгах журам
- 1.5. Газар тариалангийн бүс нутгийн үйл ажиллагааны тухай.
- 1.6. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр малжуулах төсөл хэрэгжүүлэх тухай.
- 1.7. Сумын шагналуудын журам.
- 1.8. Малын эрүүл мэндийн асуудал.

2. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг хурлын нарийн бичгийн дарга Ё.Батхуягт даалгасугай.

ДАРГА

Ц.ЭНХТҮВШИН

